



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2003 оны 5 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Авто тээврийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт:

"5.1.5. авто тээврийн хэрэгслийн төрөл, зориулалтыг нь харгалзан техникийн хяналтын үзлэгт орох хугацаа, оношлогооны төлбөрийн жишгийг ялгавартай тогтоох."

2/17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"17.4. Ашиглагдаж байгаад импортоор орж ирсэн тээврийн хэрэгслийг техникийн оношлогоонд оруулж, стандартын шаардлага хангуулсны дараа улсын бүртгэлд бүртгэж, дугаар олгоно."

3/ 19¹ дүгээр зүйл:

"19¹ дүгээр зүйл. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах.

19¹.1. Автотээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг энэ хуулийн 15.1-д заасан тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

19¹.2. Техникийн хяналтын үзлэг хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага дараахь нөхцөл, шаардлагыг хангана:

19¹.2.1. авто тээврийн хэрэгслийн техникийн ашиглалтын байдалд тавих шаардлагын дагуу техникийн хяналтын үзлэгийг /автотээврийн хэрэгслийн ерөнхий байдал, иж бүрдэл, хөдөлгүүр, хүч дамжуулах анги, тоормосны систем, жолооны механизм, гэрэл дохио, явах

анги, экологи болон эргономикийн үзүүлэлт/ бүрэн хийх;

19¹.2.2.техникийн хяналтын үзлэгийн талаархи дүрэм,журам, стандартыг мөрдөх;

19¹.2.3.үйлдвэрлэлийн байр, талбай, оношлогооны тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн стандартын үзүүлэлт, шаардлагыг хангаж, хэмжил зүйн мэргэжлийн

байгууллагаар жил бүр шалгуулж, баталгаажуулах;

19¹.2.4.гүйцэтгэсэн ажил үйлчилгээний хэмжээ, үйл ажиллагааны мэдээ, тайланг тогтоосон үзүүлэлт, загвараар эрх бүхий байгууллагад тогтмол хугацаанд

гаргаж өгөх.

19¹.3.Авто тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дараахь үүрэг хүлээнэ:

19¹.3.1.техникийн хяналтын үзлэг хийсэн гэрчилгээнд заасан хугацаанд авто тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулах;

19¹.3.2. авто тээврийн хэрэгсэл бүрийн техникийн бичиг баримтын бүрдлийг хангах."

2 дугаар зүйл.Авто тээврийн тухай хуулийн 23.1.1-ийн "17.2" гэсний дараа ",19¹.2." гэж нэмсүгэй

3 дугаар зүйл.Авто тээврийн тухай хуулийн 17.1-ийн "жил бүр" гэснийг "жилийн турш" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР